



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/144

Хужирт сум

Хамгаалалтын бүс тогтоох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-ийн 2.2, 2.4 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрчим хүчний шугам сүлжээний аюулгүй ажиллагааг хангах, засвар үйлчилгээг саадгүй явуулах, хүн, амьтан осолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Эрдэнэт-Булган Цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компаний эзэмшлийн 35/10/0,4/0,22кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 35/10,10/0,4кВ-ын дэд станцын хамгаалалтын зурвасыг хавсралтаар тогтоосугай.

2. Хамгаалалтын зурвас дотор барилга байгууламж, орон сууц, гэр хашаа барих, эрчим хүчний шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн горим, ажиллагааг алдагдуулах үйл ажиллагаа явуулахыг хориглосугай.


3. Хамгаалалтын зурваст дэглэм сахиулах, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах ажлыг хариуцан ажиллахыг Эрчим хүчний эрхлэгч (С.Цэрэндаваа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар  
сарын 20 -ны өдрийн 144 дугаар  
захирамжийн хавсралт



Хамгаалалтын зурвас

№	Шугам сүлжээний ангилал	Хамгаалалтын зурвасын хэмжээ	
		Цахилгаан дамжуулах агаарын шугам	Дэд станц
		Шугамын захын утаснаас хоёр тийш	Тал бүр тийш
1	1-20 хүртэл кВ	2 метр	10 метр
2	35кВ	4 метр	15 метр

-oOo-